

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛД

А.ГАНТУУЛ

ДХИС-ийн Удирдлагын Академийн Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: “Мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засгийн хөгжил” гэх үзэл хандлагыг дагасан шинжлэх ухааны нээлт, техник технологийн дэвшил нь хүн төрөлхтөний түүхэнд урьд байгаагүй өргөн боломжуудыг нээж өгсөн хэдий ч нөгөө талдаа уламжлалт бус харилцаа, зохист бус хэрэглээг нийгэмд бий болгожээ. Нийгэмд үүссэн тэдгээр шинэ харилцаа, зохист бус хэрэглээ нь урьд өмнө нь бидний төдийлөн анхаарч үздэггүй байсан асуудлуудыг хувирган өөрчилж, уламжлалт бус аюул, шинэ сорилтуудыг дагуулсаар байна. Тэдгээр уламжлалт бус аюул, шинэ сорилтуудын нэг нь хүрээлэн буй орчны аюулгүй байдлын асуудал болно.

Түлхүүр үгс: Хүрээлэн буй орчин, аюулгүй байдал, байгаль, экологийн тэнцвэрт байдал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшигт үзэгдэл.

Оршил

Байгаль, цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хүрээлэн буй орчны экологийн аюулгүй байдал гэж¹ ойлгоно.

Экологийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх гадаад, дотоод дараах хүчин зүйлүүд байна. Тухайлбал гадаад хүчин зүйлүүдэд:

1/ дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилт эрчимжих, хур тунадасны хэмжээ, хуваарилалт өөрчлөгдөх, ган, зудтай жилийн тоо нэмэгдэх, озоны давхарга нимгэрэх;

2/ хил дамжин агаар, усаар орж ирэх цацраг идэвхжил, химийн бохирдол, хүчиллэг бороо ихсэх, хүн амьтныг олноор хөнөөх өвчин тахал гарах, ой мод, бэлчээр, ургамлыг

устгах хортон мэрэгчид, хорхой шавьж олшрох;

3/ мансууруулах болон хүний оюун ухаан, эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх бодисын түүхий эд бэлдэх түшиц газар болон хувирах зэрэг болоод экологийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх дотоод хүчин зүйлүүдэд:

1/ экологийн тэнцвэрт байдал алдагдах, хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх, ургамал, амьтны удмын сан хомсдох;

2/ ургамал, ойн нөөц хомсдон мөрөн, гол нуур, газрын доорхи ус татарч ширгэх, нутаг бэлчээр гандан хуурайших;

3/ байгалийн нөөц баялгийг сорчлох, цөлмөх байдлаар ашиглах;

4/ хаягдал ихтэй техник, технологи хуримтлагдах хортой хог хаягдал гаргадаг үйлдвэрлэл бөөгнөрөх, гадаад орны хортой хог хаягдал булшлах газар болох² зэргийг дурьдаж болно.

¹ [www.wikipedia.org/wiki/ Экологийн аюулгүй байдал](http://www.wikipedia.org/wiki/Экологийн_аюулгүй_байдал)

² [www.wikipedia.org/wiki/ Экологийн аюулгүй байдал](http://www.wikipedia.org/wiki/Экологийн_аюулгүй_байдал)

Дээрх гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр байгаль, экологийн аюулгүй байдал алдагдаж, байгаль орчны нөхцөл байдал хурдтай доройтон хүн төрөлхтөнд бодитой аюул занал учруулахын зэрэгцээ цаашид ч ноцтой асуудлуудыг дагуулж болзошгүй нөхцөл үүсээд байгаатай судлаачид санал нэгдэж, зөвлөмж, сануулгыг өгсөөр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.4 дэх хэсэгт “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах”-ыг Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэг болгон хуульчилсан байхын зэрэгцээ “Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгасан байдаг. Эдгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр “Ногоон хөгжил”-ийг дэмжих бүлэг зорилтыг дэвшүүлжээ.

Монгол Улсын төрөөс хүрээлэн буй орчны аюулгүй байдлын асуудалд анхаарал хандуулж Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Ойн тухай, Амьтны тухай, Усны тухай, Газрын тосны тухай болон Цөмийн энергийн тухай зэрэг олон хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг

баталсан хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй байна. Энэ нь агаар, хөрсний бохирдол, цөлжилт, хариуцлагагүй уул уурхай зэргээр илэрч байна.

Нэг. Монгол Улсын хүрээлэн буй орчны өнөөгийн байдал

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэсэн хэдий ч энэ нь өнөөдөр тунхагын шинжтэй заалт болоод байна. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын хайгуул, олборлолт, замбараагүй олгосон ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл зэрэг нь байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нь эрчимжиж байна. Үүнээс шалтгаалан дэлхийн дулаарал, цөлжилт, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшгийн давтамж ихсэж, дэлхийн улс орнуудын хүрээлэн буй орчны аюулгүй байдалд шууд болон шууд бус аюул заналыг үүсгэж байна.

Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн нийгэмд шилжсэнээр ашигт малтмалын хайгуул олборлолт хийх үйл ажиллагаа эрчимжсэн байдаг. Тухайлбал: Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 304 дүгээр тогтоолоор “Алт хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлсэн байдаг. Гэвч уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн олборлолтын үйл ажиллагаа байгаль орчныг сүйтгэх, бохирдуулах, нөхөн сэргээлт хийхгүй орхих, хууль бусаар алт олборлох зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгосон юм. Хэдийгээр алт

олборлолт манай улсын эдийн засагт нэг талаас эерэг нөлөө үзүүлсэн боловч нөгөө талаас далд эдийн засаг бий болох, байгаль орчныг бохирдуулах, нөхөн сэргээлтийг хангалтгүй хийх, хууль бусаар алт олборлох зэрэг тулгамдсан асуудлыг дагуулсан.¹ Төв аймгийн Заамар суманд 1992 оноос “Алт-1” хөтөлбөр хэрэгжсэнээс хойш нийт газар нутгийнх нь 1/3 буюу 42,600 га талбайг лиценз хэлбэрээр ашигласан бөгөөд 45 компанийн зөвхөн 9 нь 2018 онд 86 га газарт нөхөн сэргээлт хийхэд 162.6 сая төгрөг зарцуулсан, бусад аж ахуйн нэгжүүд огт сэргээн сэргээлт хийхгүйгээр орхисон тухай мэргэжлийн байгууллагын тайланд дурьдсан байдаг. Байгаль орчинд нөхөн сэргээлт хийхгүй орхисоны улмаас ундны усны эх үүсвэр эрс татарч, нутгийн иргэд 10 гаруй километр явж ундны усаа залгуулах болсон нь тэдний эрүүл, аюулгүй

орчинд амьдрах эрхийг нь зөрчсөөр байгаа асуудал юм.

Нөгөөтэйгүүр Улаанбаатар хотод үүссэн хүн амын хэт төвлөрөл агаар, хөрсний бохирдлыг бий болгож, Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь амьдардаг дэлхийн хамгийн бохирдол ихтэй нийслэл хотуудын нэг болоод байна. Жилийн хамгийн хүйтэн өдөр PM2.5 бохирдлын өдрийн дундаж шоо метрт 687 микрограм хүрч байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөж буй аюулгүй төвшнөөс 27 дахин их байна². Агаарын бохирдол гэдэг нь хүн ба бусад амьд биетээс шалтгаалсан хувилахуйн болон амин бодисууд, элдэв тоосжилтын нөлөөнд агаар мандлын байгалийн шинж чанар өөрчлөгдөх³ тухай ойлголт юм.

Улаанбаатар хотын хувьд агаарын бохирдлын хувьд их байгаа нь дараах судалгааны дүнд харуулж байна.



¹ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоол, “Алт-2 үндэсний хөтөлбөр”-ийн үндэслэл шаардлага хэсэг

² <https://www.unicef.org/mongolia/mn/environment-air-pollution>

³ <https://www.agaar.mn/files/article/664/Agaaarin%20bohirdiin%20tuhai%20tovchhon.pdf>

Улаанбаатар хотод үүссэн агаар, хөрсний бохирдол Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж, улмаар хүн амын эрүүл мэндэд ноцтой үр дагаврыг үүсгэх болжээ. Агаарын бохирдол нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж амьсгалын замын, зүрх судасны, төв мэдрэлийн системийн өвчлөл, харшлын өвчнүүд, удамшлын эмгэг, төрөлхийн гажиг зэрэг өвчнүүдийн тархалт, тохиолдлын түвшнийг ихэсгэх, улмаар нөхөн үржихүйн эрүүл мэндийг хордуулах (үр хөврөл гэмтэх, дутуу төрөх, ураг өсөлтгүй болох), хүүхдийн дархлаа, өсөлт хөгжлийг бууруулахад нөлөөлж байгаа төдийгүй хорт хавдар үүсгэгч хүчин зүйлийн нэг болж байна. Тодруулбал: Өнгөрсөн 10 жилд Улаанбаатар хотын оршин суугчдын дунд амьсгалын замын өвчин асар хурдтай нэмэгдэж, 10,000 хүн тутамд амьсгалын замаар халдвар авах тохиолдлууд 2.7 дахин нэмэгдсэн. Монголд өвөл зуны хооронд тэмдэглэгдсэн үр зулбалт 3.5 дахин нэмэгдсэн байна.¹

Түүнчлэн Монгол Улсын Хавдар судлалын үндэсний төв /ХСҮТ/-ийн судлаачдын баг болон Франц, Испани, Сингапурын их сургууль, Нью-Йорк дахь судалгааны хүрээлэн зэрэг гадаад, дотоодын 14 байгууллагын эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгааны ажлын үр дүнг ХСҮТ-ийн ерөнхий захирал, доктор Н.Эрдэнэхүү АШУҮИС-аас 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Угаартсаар байхуу Улаанбаатарчуудаа” нээлттэй хэлэлцүүлгийн үеэр мэдээлсэн. Уг судалгааны тайланд: “...Элэгний хавдар нь В, С, D вирусээс зонхилон үүсэх хэдий ч Монгол Улсад элэгний хавдараар өвчлөгсдийн 25 хувь нь гадаад орчны шалтгаантай үүссэн

элэгний хавдар байна. Орчны шалтгаантай хавдарын 71 хувь нь нүүрс шатааснаас үүссэн хүхрийн хэт исэл, хар тугалга зэрэг хүчин зүйл нь хүний биед мутаци үүсгэж байна. Бусад улс орнуудад энэ төрлийн мутаци байхгүй зөвхөн Монголд хүнд үүсч байгаа мутаци юм гэсэн судалгааны дүгнэлт гарсан. Утаа элэгний эсэд хавдар үүсгэж байгаа бол бусад эрхтэн тухайлбал нойр булчирхай, хөх гээд сүүлийн жилүүдэд ихсэж байгаа хавдарт ч нөлөөлнө. Зөвхөн хавдар ч гэлтгүй амьсгалын замын олон янз өвчнийг үүсгэдэг. Уг судалгаагаар мутацилагдсан элэгний хорт хавдар зөвхөн Монгол хүнд л илэрч байгаа нь үнэхээр сэтгэл эмзэглүүлсэн асуудал юм.”² гэжээ. Монгол Улсад элэгний хорт хавдараар өвчлөн, нас барж байгаа иргэдийн тоогоор дэлхийд тэргүүлсэн үзүүлэлттэй байгаа нь эмзэглэх асуудал хэдий ч гадаад орчны шалтгаант тэр дундаа агаарын бохирдол хорт хавдарыг үүсгэх шууд шалтгааны нэг болж байгаа нь туйлын эмзэг, Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд заналхийлсэн хүчин зүйл болж байна.

Түүнчлэн Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл хэт ихсэж, хатуу ба шингэн бохирдлын хэмжээ жил ирэх бүр ихсэж байна. Нийт хатуу хог хаягдлын 70 орчим хувийг ахуйн хог хаягдал эзэлдэг бөгөөд Улаанбаатар хотод хоногт дунджаар 800-1000 тонн орчим хатуу хог хаягдал гардаг гэсэн судалгааны дүн байдаг. Эдгээр хог хаягдлын 20-30 орчим хувь нь зориулалтын хогийн цэгт хаягдахгүйгээр ил задгай хөрс, гуу жалганд хаягддаг байна. Нийслэл хотын хүн амын 60 гаруй хувь буюу 200 орчим мянган өрх гэр хороололд амьдарч нүхэн жорлон ашиглаж

1

<https://www.unicef.org/mongolia/mn/environment-air-pollution>

² <https://www.ulsturch.mn/article/56553>

байна. Нүхэн жорлонгийн шингэн бохирдол нь газрын доорх ус болон хөрсийг бохирдуулагч томоохон бохирдлын эх үүсвэр болно. Мөн Улаанбаатар хотод нийтийн бие засах газрын хүрэлцээ хангамж дутагдалтайгаас иргэд ил задгай газар бие засах зэргээр хөрсийг маш ихээр бохирдуулсаар байна.


Хоёр. Дэлхийн дулаарал, цөлжилт

Дэлхийн дулаарал, түүнээс үүдэлтэй цөлжилтийн асуудал хүн төрөлхтөний өмнө аюулгүй байдлын шинэ сорилтыг бий болгож байна. Сүүлийн 100 жилийн хугацаанд Дэлхийн дундаж температур 0.74 ± 0.18 градусаар нэмэгдсэн бөгөөд Монгол орны хэмжээнд дундчилсан байдлаар жилийн агаарын температур 2.25 градусаар дулаарч, хур тунадасны хэмжээ 8 хувиар буураад байна.¹

Засгийн Газар хоорондын Уур амьсгалын өөрчлөлтийн хороо /Intergovernmental Panel on Climate Change-IPCC/-ноос: "XX зууны дундаас эхэлсэн, агаарын дундаж температурын ихсэлт нь агаар мандал дахь антропоген хүлэмжийн хийн агууламж нэмэгдсэнтэй холбоотой байх бүрэн боломжтой юм."² гэжээ. Дэлхий дулааралтай холбоотойгоор цөлжилтийн асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болж байгаа бөгөөд 1994 онд Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцыг баталж, Монгол Улс 1996 онд уг конвенцэд нэгдэн оржээ.

Монгол Улс цөлжилттэй тэмцэх зорилгоор 2010 онд "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр", 2012 онд Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх

тухай хуулийг баталжээ. Монгол орны цөлжилтөд хариуцлагагүй уул уурхай, бэлчээрийн мал аж ахуй ихээхэн нөлөөлж³ байна. Монгол орны хувьд малын бэлчээрийг ашиглахдаа сэлгэн нүүдэллэх зарчмаар чөлөөтэй ашиглуулдаг боловч уур амьсгалын өөрчлөлт болон малын тоо толгой хэт ихсэж, бэлчээрийн даацыг хэтрүүлснээс хөрсний доройтол болон ургамлын аймагт сөрөг нөлөөлөл үзүүлж нийт нутаг дэвсгэрт цөлжих үзэгдлийг нэмэгдүүлж байна. 2020 оны байдлаар Монгол орон цөлжилтийн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтсноос нэн хүчтэй 4.7 хувь, хүчтэй 18.6 хувийг эзэлж байна. Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50-70 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн⁴ байна гэсэн дүгнэлтийг байгаль орчны хамгаалах мэргэжлийн байгууллагын судалгааны тайланд дурьджээ.



Зураг 2.

¹ <https://eic.mn/dldbase/>

² https://mn.wikipedia.org/wiki/Уур_амьсгалын_өөрчлөлт

³ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим мэдээлэл

⁴ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим мэдээлэл

Дүгнэлт

Хүрээлэн буй орчны аюулгүй байдлын асуудал нь Монгол Улсын төдийгүй дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэ ч утгаараа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Муний 2016 онд санаачилсан “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр /Paris Climate Accords/”-ийг хүчин төгөлдөр болгохыг уриалсан дээд түвшиний арга хэмжээнд дэлхийн бусад улс орнуудыг хэлэлцээрт нэгдэхийг уриалж Монгол Улс оролцож байсан билээ. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулж, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох, дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2 хэмээс хэтрүүлэхгүй байж, улмаар 1.5 хэмд хязгаарлах амлалтыг дэвшүүлсэн түүхэн ач холбогдолтой олон улсын хэмжээний баримт бичиг юм.

Санал

Монгол Улс улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлэх, байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагатай уул уурхайг цогцлоож, хууль тогтоомж, стандартыг чанд мөрдөх шаардлагатай юм.

Нөгөөтэйгүүр агаар, хөрсний бохирдол нь Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас иргэд олноор ирж суурьшиж байгаатай холбоотойгоор үүсэж байгаа тул орон нутгийг хөгжүүлэх бүсчилсэн бодлогыг дэмжих, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, зам, тээвэр, дэд

бүтцийн асуудлыг яаралтай шийдвэрлэж хотыг тэлж хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах арга хэмжээ авах, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг эрчимжүүлж, байгаль орчныг хамгаалах чиглэлд иргэд, олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалт сурталчилгааг нэмэгдүүлэх зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

а/ Монгол Улсын хууль, тогтоомж:

-Монгол Улсын Үндсэн хууль;

-Байгаль орчныг хамгаалах тухай хууль;

-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

-Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.

б/ Судалгааны тайлан, цахим эх сурвалж:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим мэдээллийн сан /2021 он/

-Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 304 дүгээр тогтоол “Алт хөтөлбөр”

-Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоол “Алт-2 үндэсний хөтөлбөр”.

-

<https://www.unicef.org/mongolia/mn/en/vironment-air-pollution>

-

<https://www.ulsturch.mn/article/56553>;

- <https://eic.mn/dldbse/>;

-

https://mn.wikipedia.org/wiki/Уур_амьсгалын_өөрчлөлт;

-www.wikipedia.org/wiki/

Экологийн аюулгүй байдал;